



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 677

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай 2021 оны 228 дугаар тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтын 4, 6, 42 дугаар хуулийн этгээдүүдийн 2021 оны улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг 2022 оны хоёрдугаар улиралд багтаан төвлөрүүлэхээр хойшлуулсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

- 132001168 -

\Huraldaanii material\2021 он\2021.12.23 23-р huraldaan.docx